

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.12.02 - 12.06

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өөрчлөлт багатай хаагдлаа. АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны маргаантай холбоотойгоор тодорхойгүй бус байдлын нөлөөг ажил эрхлэлтийн тайлан эерэг байсан нь сааруулав.

S&P 500 индексийн сагсанд багтах Procter & Gable компанийн хувьцаа их хэмжээний өсөлт үзүүлсэнтэй холбоотой өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний салбар өсөлттэй байсан бол Boeing компани 737 Max загварын тодорхойгүй байдлаас үүдэн Airbus компанид борлуулалтаа алдаж байгаа нь үйлдвэрлэлийн салбарт уналт үүсгэх шалтгаан болов. Мөн, тээвэрлэлтийн салбар UPS, FedEx болон United Airlines компаниуд алдагдалтай ажилласантай холбоотой сул байлаа.

АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп Даваа гарагт Бразил болон Аргентин улсуудад ган болон хөнгөн цагаан дээр гаалийн татвар ногдуулна мөн БНХАУ-тай 2020 оны сонгуулийн дараа худалдааны хэлэлцээр хийсэн нь дээр хэмээсэн нь хөрөнгийн зах зээлийн индексүүд буурахад нөлөөлсөн ч Мягмар гарагт БНХАУ-тай хийж буй худалдааны хэлэлцээр ахицтай байгаа гэсэн мэдэгдэл хийсний дараа хөрөнгийн зах зээлийн индексүүд алдагдлаа нөхжээ.

Европ: Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны хэлэлцээр 2020 оны ерөнхийлөгчийн сонгуулийн дараа хийгдэх магадлалтайгаас үүдэн уналттай эхэлсэн ч ажил эрхлэлтийн тайлан эерэг гарсантай холбоотойгоор өссөн байна.

Их Британийн фунтийн ханш Консерватив нам бүх нийтийн сонгуулиар ялах магадлал их байгаатай холбоотой ам.долларын эсрэг чангарчээ.

Евро бүсийн хамгийн том эдийн засагтай улсууд болох ХБНГУ болон Франц улсуудын улс төрийн тогтворгүй байдал Евро бүсийн эдийн засагт сөргөөр нөлөөлөх магадлалтай байна. Гэхдээ, 11-р сарын эдийн засгийн тайлангаар Европын төв банкны зөөлөн бодлогоос үүдэн эдийн засгийн уналт тогтворжсон байдалтай байна.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Япон улсын Ерөнхий сайд ноён Шинзо Абэ 13 тэрбум иенийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр танилцуулжээ. Энэхүү хөтөлбөр нь шинээр хэрэгжиж эхэлсэн НӨАТ, экспортын бууралт болон байгалийн гамшигт үзэгдэлүүдээс үүссэн эдийн засгийн удаашралын эсрэг авч буй арга хэмжээ юм.

Хэдийгээр Япон улсын эдийн засаг энэ жил өсөлттэй байсан ч шинжээчид худалдааны маргаантай асуудлууд болон Brexit-ээс үүдэн эдийн засгийн өсөлт сул байгаа гэж үзэж байна.

БНХАУ: БНХАУ-ын хөрөнгө оруулагчид АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны эхний шатны хэлэлцээр ахицтай байгаа гэж үзэж байгаагаас үүдэн хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа. Мөн, БНХАУ-ын үйлдвэрлэлийн хэмжээ 2016 оны 12 сараас хойших хамгийн өндөр өсөлтийг үзүүлжээ.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	18,685.40	-0.47% ▼
Dow Jones	АНУ	28,015.06	-0.13% ▼
S&P 500	АНУ	3,145.91	0.16% ▲
Nasdaq	АНУ	8,656.53	-0.10% ▼
S&P/TSX	Канад	16,996.97	-0.25% ▼
FTSE 100	Их Британи	7,239.66	-1.45% ▼
S&P/ASX 200	Австрали	6,707.00	-2.03% ▼
Nikkei 225	Япон	23,354.40	0.26% ▲
Hang Seng	Хонг Конг	26,217.04	-0.49% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	112.95
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	102.90
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	102.01
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.27
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.26
DBM' 2023	USD	7.250%	105.78
TDBM' 2020	USD	9.375%	102.41
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	97.33

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	1.715	0.02 ▲
Libor 3M	1.890	-0.02 ▼
Libor 6M	1.886	-0.01 ▼
Libor 1YR	1.923	-0.03 ▼
US 2YR Bond	1.619	0.00 ▼
US 3YR Bond	1.639	0.01 ▲
US 5YR Bond	1.664	0.01 ▲
US 10YR Bond	1.838	0.03 ▲

Валютын ханш /төг/

Валют	2019.12.06	Өөрчлөлт
USD	2,721.72	0.24% ▲
CNY	387.11	0.18% ▲
EUR	3,023.01	1.11% ▲
RUB	42.71	0.83% ▲
KRW	2.29	-0.43% ▼
JPY	25.04	0.97% ▲
CAD	2,065.35	1.03% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,460.17	-0.26% ▼
Мөнгө /spot/	USD/t oz.	16.58	-2.03% ▼
Зэс	USD/lb.	272.50	2.39% ▲
Нүүрс	USD/MT	68.82	-4.42% ▼
WTI газрын тос	USD/bbl.	59.20	7.30% ▲
Brent газрын тос	USD/bbl.	64.39	3.14% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. X	7.60%
Бодлогын хүү	2019. X	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. X	11.06%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. X	11.48%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. X	4.82%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. X	16.90%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. X	10.61%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 44 компанийн 743.9 сая төгрөгийн 2,190,245 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Хишиг Уул” /HSX/ компанийн хувьцаа 32.05%-аар буюу хамгийн ихээр өсөж 515.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Монгол савхи” /UYN/ компанийн хувьцаа 14.92%-аар буурч 553.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

12-р сарын 09-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,542.1 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 18,685.40 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.47%-аар буурсан байна.



Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	743.9
Зах зээлийн үнэлгээ	2,542,077.0

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	18,685.40	-0.47% ▼
MSE I индекс	8,820.19	1.04% ▲
MSE II индекс	7,672.47	-0.47% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Инвескор ББСБ	114,732	214,781,859
Хөвсгөл алтан дуулга	184,006	129,355,379
Монгол шуудан	141,378	74,938,352
Ард кредит ББСБ	931,170	70,378,633
Могойн гол	6,262	56,358,000

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хишиг уул	515.00	32.05% ▲
Дархан нэхий	12,000.00	17.65% ▲
Говийн өндөр	142.60	15.00% ▲
Агротехимпекс	1,045.00	14.71% ▲
Монгол базальт	265.00	4.13% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Монгол савхи	553.00	-14.92% ▼
Авто импекс	1,325.00	-14.52% ▼
Монгол нэхмэл	1,810.00	-13.81% ▼
Монгол шуудан	530.06	-12.96% ▼
Монголын цахилгаан холбоо	405.00	-10.00% ▼


Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ти Ди Би Капитал	417,514,540
Бумбат-Алтай	329,505,758
Ард Секюритиз	197,368,247
Гаули	115,096,728
Голомт Капитал	91,226,034

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	585.51	623,089
Таван толгой	6,550.00	344,957
МИК Холдинг	12,640.00	261,766
Говь	255.52	199,334
Инвескор ББСБ	2,167.00	155,434

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
---	-----------------	--------------------	-----------------	------------	------------	---------	-----

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.21-нд олгов
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор
32	HRM	Гермес центр ХК	481.3	447.7	93.0%	5.7	2019.08.15	2019.09.02	2019.09.18-нд олгов
33	SUU	Сүү ХК	5,706.4	1,143.4	20.0%	3.3	2019.09.09	2019.04.05	2019.10.24-нд олгов

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Хорооны дарга Д.Баярсайхан ЖАЙКА-ийн төлөөлөгчидтэй уулзав

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа.

Хороо “Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх II үе шатны төсөл”-ийн хоёрдугаар үе шатыг Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран 2019 оны 3-р сараас хэрэгжүүлж байгаа билээ. Төслийн хүрээнд Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн (ERI)-ээс энэ оны 3-р сараас эхлэн 5 сарын хугацаанд “Монгол дахь бондын зах зээлийн өнөөгийн байдал” сэдэвт судалгааг хийсэн. Судалгааны багт олон улсын зөвлөх Норитака Акамацү ажиллаж “Компанийн бондын зах зээлийг хөгжүүлэх” тайланг бэлдэж танилцуулав.

Мөн төслийн багийнхан Хорооны албан хаагчид болон бусад зах зээлд оролцогчдод зориулан сургалт хийлээ.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

СЗХ, ЖАЙКА-ын хамтарсан төслийн удирдах зөвлөлийн хурал боллоо

Санхүүгийн зохицуулах хороо, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх II үе шатны төслийг 2019 оноос хэрэгжүүлж байна.

Төсөл нь компанийн бондын зах зээлийн нөхцөл байдлын судалгаа хийж, зөвлөгөө өгөх, зэрэглэл тогтоох байгууллага байгуулах болон биржийн бус арилжааны эрх зүй, зохицуулалт, тогтолцооны зарчмыг тодорхойлж боловсруулах, олон нийтийн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлж, зах зээлд оролцох сонирхлыг нэмэгдүүлэх гэсэн гурван чиглэлээр хэрэгжиж байгаа билээ.

Энэ төслийн хамтарсан удирдах хороо (JCC)-ны 2019 оны анхдугаар хурал болж, 2019 онд хэрэгжүүлсэн ажлаа дүгнэж, 2020 онд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэж баталлаа.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

“Мост финтек”-ийн хувьцааг бүртгэлээс хасав

Дотоодын хөрөнгийн зах дээр IPO гаргах зөвшөөрөл аваад байсан “МОСТ Финтек” компани уг үйл ажиллагаагаа цуцалсан талаар бид өмнө мэдээлж байсан билээ.

Тэгвэл СЗХ-ноос тус компанийн нэг бүр нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 466,716,642 ширхэг хувьцааг бүртгэлээсээ хасах шийдвэрийг гаргасан байна.

Нэмж хэлэхэд энэ нь дотоодын хөрөнгийн зах дээр IPO гаргах зөвшөөрөл авсны дараа өөрийн хүсэлтээр цуцалж буй цөөн тохиолдлын нэг юм.

Эх сурвалж: MarketInfo.mn

Хорооны ээлжит XVII хуралдаан болов

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны ээлжит XVII хуралдаан болж нийт 28 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Хуралдаанаар “Мик актив-21” ХХК-ийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг, “Ард санхүүгийн нэгдэл” ХК болон “Ард кредит ББСБ” ХК-ийн хаалттай хүрээнд санал болгож буй өрийн хэрэгслийг тус тус бүртгэж, “Райнос инвестмент” ХХК-д үнэт цаасны зах зээлд брокер, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл болон номинал дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх, гадаадулсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах зөвшөөрөл олгов. Түүнчлэн “Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулсан хувийн хөрөнгө оруулалтын сангийн баримт бичгийг бүртгэлээ. Мөн “Тээвэр хөгжлийн банк” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, зарим даатгалын компанийн даатгалын бүтээгдэхүүн, бүтцийн өөрчлөлт, эрх бүхий албан тушаалтныг бүртгэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

Нэр бүхий үнэт цаасны компани, хадгаламж зээлийн хоршоо, ББСБ-уудын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг сунгах, тусгай зөвшөөрөл нэмж олгох зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

Иргэд хөрөнгө оруулалтын сангаар дамжуулан зах зээлд оролцох эрх зүйн орчин бүрдлээ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 6-р сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолоор батлагдсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалттай сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны 11-р сарын 13-ны өдрийн 537 тоот тушаалаар батламжилсан билээ. Энэхүү журмыг олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд 12-р сарын 06-ны өдөр зах зээлийн мэргэжлийн оролцогчид болох хөрөнгө оруулалтын менежментийн болон үнэт цаасны компаниудад зориулсан танилцуулга, сургалтыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иас зохион байгууллаа.

“Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам” хэрэгжиж эхэлснээр, хөрөнгө оруулалтын сангууд нэгж эрхээ Биржид бүртгүүлж, олон нийтэд нээлттэй арилжих, татан төвлөрүүлсэн хөрөнгийг нэгж эрх эзэмшигчдийн өмнөөс мэргэжлийн удирдлагаар хангаж, хөрөнгийн зах зээлд тодорхой хувийг оруулах, улмаар дотоодын зах зээлд нэн шаардагдаж буй урт хугацааны мэргэжлийн хөрөнгө оруулагчид бий болох боломж нээгдэж буй онцгой ач холбогдолтой юм.

Сургалтаар хамтын хаалттай сангийн талаар үндсэн ойлголт, олон улсын практик туршлагаас хуваалцсанаас гадна сан үүсгэн байгуулж СЗХ болон МХБ-д бүртгүүлэх эрх зүйн нөхцөл байдал, бүртгэлтэй байх хугацаанд тогтмол хэрэгжүүлэх үүргийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөв.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Эрдэнэ ресурс девелопмент корпораци” ХК нь баян хөндий алтны төслийн урьдчилсан ТЭЗҮ-ийг бүртгүүлж, Европын сэргээн босголт хөгжлийн банкны оролцоотой хийсэн санхүүжилтийг хаалаа

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци” ХК (TSX:ERD | MSE:ERDN) (цаашид “Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” гэх) нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт орших өөрийн 100% эзэмшлийн өндөр агуулга бүхий илээр олборлох боломжтой Хөндий Алтны Төслийн хараат бус техникийн тайланг SEDAR (“System for electronic document analysis and retrieval”)–т бүртгүүлснийг зарлахад таатай байна. Энэхүү техникийн тайланд Баян Хөндий ордын (“Bayan Khundii”) урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл (“урьдчилсан ТЭЗҮ” буюу “PFS”) болон Баян Хөндийгөөс 16 км зайд зайд орших Алтан Нар ордын (“Altan Nar”) шинэчилсэн анхан шатны эдийн засгийн тооцоолол (“АШЭЭТ”) орсон болно. Тайланг Tetra Tech Inc (“Tetra Tech”) NI 43-101 эрдсийн нөөцийн тайлагналын стандартын (“NI 43-101”) дагуу боловсруулж, Хөндий Алтны Төслийн NI 43-101 Техникийн Тайлан (“Khundii Gold Project NI 43-101 Technical Report”) нэртэйгээр 2019 оны 12-р сарын 4-нд бүртгүүлээ. Тайлантай www.sedar.com дахь компанийн хуудас болон компанийн www.erdene.com вебсайтаас танилцах боломжтой.



Компани нь Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (“the European Bank for Reconstruction and Development”) буюу “ЕСБХБ”)–ны оролцоотой санхүүжилтийн багцыг танилцуулж байсан. Дээрх санхүүжилттэй холбоотойгоор ЕСБХБ–аас 5 сая америк доллар (6.6 сая канад доллар), мөн 1 сая канад долларын зуучлалгүй хаалттай санхүүжилтийн орлогыг хүлээн авсныг мэдээлэхэд таатай байна. Санхүүжилт нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”)–ийг хараат бус эцсийн ТЭЗҮ (“FS”), анхан шатны инженерийн загварчлал (“FEED”), хайгуул болон хөрөнгө оруулалтын зардлууд, эргэлтийн хөрөнгөд зарцуулагдана.

Эх сурвалж: Erdene.com

Махыг зах зээлийн үнээс 500-1,000 төгрөгөөр хямд худалдаж байна

Төв суурин газрын хүн амын махны хангамжийг нэмэгдүүлэх зорилготой “Өвлийн идэш” махны өргөтгөсөн худалдаа Яармагийн зам дагуу байрладаг “Сансар”, Нарны замд байдаг “Саруул” худалдааны төв, Чингис зочид буудлын эсрэг талын “Скай” их дэлгүүрт энэ сарын 5-20-нд үргэлжилнэ. Өргөтгөсөн худалдаагаар иргэд өвлийн хэрэгцээний махаа зах зээлийн үнээс 500-1,000 төгрөгөөр хямд худалдан авах боломжтой.

Өргөтгөсөн худалдаагаар эрүүл ахуйн үзлэг шинжилгээнд хамрагдсан, уламжлалт аргаар шаардлага хангасан мал нядалгааны цэгт бэлтгэсэн мах, малын дайвар бүтээгдэхүүнийг дундын зуучлагчгүй үнээр худалдах юм. Өргөтгөсөн худалдаанд Булган, Дорноговь, Төв, Өмнөговь, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл, Сүхбаатар, Увс, Ховд, Өвөрхангай зэрэг 11 аймгийн малчид оролцож байна.

ХХААХҮЯ–аас гаргасан судалгаагаар энэ оны 9-р сарын байдлаар бэлчээрт 84.2 сая толгой мал байгаагаас 16.5 саяыг хэрэгцээлэх, 67.7 сая малыг өвөлжүүлэх тооцоо гарчээ. ХХААХҮ–ийн дэд сайд Ж.Сауле: “Манай яам махны үнийг одоогийн үнээс өсгөхгүй байхыг зорьж байна. Жишээлбэл, хонины махыг 6,000 төгрөгөөс хэтрүүлэхгүй байх санал тавьж байгаа ч малчид хувиараа мал махаа борлуулж буйтай холбоотойгоор үнэ зөвхөн яамнаас шалтгаалахгүй байна” гэлээ.

Дундговь аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ: “Өнөөдрийн байдлаар, манай аймгаас гурван сумын малчид 200 гаруй бог, 50 гаруй бодын махтай хүрэлцэн ирсэн байна. Маргаашаас энэ тоо нэмэгдэнэ. Энэ жил манай нутагт өвөлжилт хүндэрч, отор нүүдэл ихтэй байгаатай холбоотой зах зээлд нийлүүлж буй махны бага байна. Дундговийн мах амт шимтээрээ хэрэглэгчдэд хэдийнээ танигдсан” хэмээв.

Эх сурвалж: Montsame.mn

Монголбанк 14.4 тонн алт худалдан авлаа

Монголбанк 2019 оны эхний 11 сард 14.4 тонн үнэт металл худалдан авсан нь өмнөх оны мөн үед 18.9 тонн үнэт металл худалдан авснаас 4.5 тонноор бага буюу 24%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Монголбанк 2019 оны 11-р сард 1.5 тонн үнэт металл худалдсан авсан ба үүнээс Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 11.3 кг үнэт металл, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 19.4 кг үнэт металлыг худалдаж авсан нь өмнөх оны мөн үед 1.2 тонн үнэт металл худалдан авч байснаас 0.3 тонноор өссөн үзүүлэлттэй байна. 2019 оны 11-р сард 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 128,002.45 төгрөг байлаа.

Эх сурвалж: Монголбанк

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК–ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.